



ДОРНОГОВЬ АЙМАГ
АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 9/56

Чулуунгишгэр

Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 14/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын “Газар зохион байгуулалтын 2024 төлөвлөгөө”-нд тусгагдсан газарт газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохих журмын дагуу танхимын хэлбэрээр зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газарт үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/23 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Баярсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Н.БҮРЭНТЭГШ

Ddisk/Zahiramj

4424020103

Алтанширээ сумын Засаг даргын
2024 оны 04 дугаар сарын 29-ны өдрийн
1/56 дугаар захирамжийн хавсралт



ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Газрын байршил	Газрын зориулалт	Талбайн хэмжээ (га)	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Дуудлага худалдааны анхны үнэ (төг)	Дэнчингийн хэмжээ (төг)
1	2	3	4	5	6	7
1	2-р баг, Газрын тос боловсруулах үйлдвэрийн хойд талд	Худалдаа үйлчилгээний газар	0.05	3837629	300,000 ₮	30,000